



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

2014 оны төлөвлөгөө батлах тухай

Төсвийн шууд захирагчдад төсөв зарцуулах эрх олгох, батлагдсан төсвийг хуулийн дагуу зарцуулах, өртөг зардлыг хэмнэх, төсвийн сахилгыг чангатгах, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах зорилгоор Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийг удирдлага болгон ТУШААХ нь:

Нэг. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжийн 2014 оны орон тоо, цалингийн санг нэгдүгээр хавсралтаар, урсгал төсвийн зарлагын санхүүжилтийг хоёрдугаар хавсралтаар, сарын хуваарийг гуравдугаар хавсралтаар, хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний зарлагын санхүүжилтийг дөрөвдүгээр хавсралтаар, үйлдвэр, борлуулалтын төлөвлөгөөг тавдугаар хавсралтаар, бүтээгдэхүүний нэр төрлийн төлөвлөгөөг зургаадугаар хавсралтаар, газар тариалангийн төлөвлөгөөг долоодугаар хавсралтаар, мал аж ахуйн төлөвлөгөөг наймдугаар хавсралтаар, ялтны ажлын байрны төлөвлөгөөг есдүгээр хавсралтаар, дээд байгууллагад төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг аравдугаар хавсралтаар, Шийдвэр гүйцэтгэлийн урамшууллын орлогын санхүүжилтийг арваннэгдүгээр хавсралтаар, төрийн өмчит үйлдвэрийн газрын удирдлагын зардлыг арванхоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Монгол Улсын Их Хурлаар батлагдсан төсөв болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас олсон орлогыг үр ашигтай зарцуулах, төсвийн хөрөнгийг хэмнэж, байгууллагын үргүй зардлыг журамлах зорилгоор дараах арга хэмжээ авч ажиллахыг нийт хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжийн дарга нарт үүрэг болгосугай. Үүнд:

1/ Төсвийн жилд баталсан урсгал төсөв, хөрөнгө оруулалтын зардлыг зориулалтын дагуу зарцуулж, бололцоотой зардлыг хэмнэх, төвлөрүүлэх орлого, үйлдвэрлэлт, борлуулалтын төлөвлөгөөг холбогдох хууль, журмын дагуу хэрэгжүүлж, төсвийн сахилга батыг чанд сахиж, ер, авлага үүсгэхгүй байх, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх;

2/ Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан ажилчин, албан хаагчдын цалин хөлсийг холбогдох хууль журмын дагуу тогтоох;

3/ Дээд байгууллагаас гаргасан нормативыг баримтлан албан тушаалын болон албан ажлын автомашин хэрэглэх, суудлын автомашины гүйлтийн лимитийн хэмжээг хатуу мөрдөж, хэтрүүлсэн шатахууны үнийг хэрэглэгчээр нөхөн төлүүлж байх;

4/ Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах түлш, халаалтын зардлыг хэмнэх хэлмэлтийн горимыг сонгох, цахилгаан эрчим хүч, усыг ариг гамтай зарцуулах;

5/ Албан хаагчдын гадаад, дотоод албан томилолтын жилийн хуваарийг батлуулж, зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд томилолт олгохгүй байх, томилолтын тайлан, үр дүнг тогтмол дүгнэх;

6/ Сургалт, семинарын нэгдсэн хуваарьт зааснаас бусад хугацаанд заавал биечлэн ирэхгүйгээр мэдээлэл, технологийн дэвшил /онлайн, зайны, телефон, факс/-ийг өргөн ашиглаж, дотоод томилолтын зардлыг багасгах, мөн төрийн бус байгууллагын шугамаар зохион байгуулах сургалт, семинар, бусад арга хэмжээнд албан хаагчдыг оролцуулах асуудлыг тухай бүр шийдвэрлэж, эдгээр арга хэмжээнд төсвийн болон байгууллагын дотоод орлогын зардлаар оролцохыг хориглох;

7/ Электрон шуудан, интернетийн холбоо ашиглах замаар шуудан холбоо, бичиг хэргийн зардлыг хэмнэх, тогтоосон нормативыг баримтлах;

8/ Баяр ёслолыг тэмдэглэхдээ үр ашиггүй, үрэлгэн зардал гаргадаг байдлыг таслан зогсоож, мэндчилгээ хэвлүүлэх, урлагийн тоглолт захиалах, хэт өндөр үнэтэй урамшуулал, шагнал өгөхийг багасгаж, төсвийн болон байгууллагын дотоод орлогоос зарцуулахгүй байх;

9/ Батлагдсан урсгал төсвийн хөрөнгийг зориулалтаар нь орон тоо, цалин хөлс болон бусад зардлыг зүйл бүрээр нь зохих нормативын хүрээнд, үргүй зардал гаргахгүйгээр үндэслэлтэй зөв зарцуулан, төсвийн хэтрэлт, хэмнэлтийг сар бүр тооцон дүгнэж, хүндэтгэх шалтгаанаар зардал нэмэгдсэн тохиолдолд харъяалах дээд байгууллагад төсвийн хүрээний мэдэгдлийг зохицуулах саналаа ирүүлж, шийдвэрлүүлэх;

10/ Холбогдох байгууллагаас баталсан маягтын дагуу төсвийн болон статистикийн мэдээ, тайланг тогтоосон журмын дагуу заасан хугацаанд бүрэн ирүүлж байх;

11/ Иргэн, байгууллагад учруулсан хохирлыг нөхөн барагдуулах зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 121, 122 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2013 оны А/32 дугаар тушаалыг тус тус үндэслэн ялтны ажлын байраар хангах ажлыг зохион байгуулах, хийсэн хөдөлмөрт нь ногдох цалин хөлсийг бодож олгох, шүүхийн шийдвэртэй төлбөрийг тухай бүр суутган, шилжүүлэх;

12/ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас батлан хүргүүлсэн үйлдвэрлэл, барилга угсралтын ажлын даалгаврыг биелүүлэх удирдлага зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч, батлагдсан норм, дүрэм, жишиг стандартын дагуу технологийн шинэчлэлийг тусган, барилгын хийц, бүтээцийн чанарт онцгой анхааран, гүйцэтгэлийг шинэчлэгдсэн дүрмийн дагуу тайлагнаж, тогтоосон хугацаанд холбогдох дээд байгууллагад мэдээлж, үйл ажиллагаагаа улам эрчимжүүлж, үйлдвэрлэл, борлуулалтыг нэмэгдүүлж ажиллах;

13/ Хоол, хүнсний бүтээгдэхүүний чанар, нийлүүлэлтэд онцгой анхаарч, тогтоосон норм нормативын дагуу халуун хоол, хүнсээр үйлчлэх;

14/ Төсвийн тухай хуулийг нэг мөр хэрэгжүүлж, батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, ил тод, нээлттэй болгох, худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлэх;

15/ Түүнчлэн ялтанд цалин хөлс бодож олгох, төлбөрт суутгах, гар дээр олгох, нэрийн дансанд шилжүүлэх зэрэг цалинтай холбоотой харилцааг сайтар ойлгуулах, цалин бодож буй албан тушаалтан цагийн тооцоо, хөдөлмөрийн хөлсийг хуульд заасны дагуу бодож олгож байхыг анхаарч ажиллахын зэрэгцээ түүнийг хоригдоход нэг өдөрт ногдох зардлыг ойлгомжтой байдлаар таниулах;

16/ Мал амьтдын тоо толгойг өсгөх, сүргийн үндсэн бүтцийг чанаржуулах, энгийн ашиг шимтэй малаас гадна эрчимжсэн, өгөөж сайтай төллөх эх малын тоо толгойг нэмэгдүүлж, мах, цувдай, сүү цагаан идээний хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, арьс шир, ноос ноолуур зэрэг түүхий эдийг борлуулах, цаашлаад эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, зах зээлийн эргэлтэд оруулж, албан хаагчдын нийгмийн асуудлыг дээшлүүлж, ялтны амьдрах орчинг сайжруулах зорилгоор туслах үйл ажиллагаа, үүнээс мал аж ахуйгаа эрчимтэй хөгжүүлж, түүний үндсэн дээр байгууллагын санхүүгийн чадавхийг бэхжүүлэхийн зэрэгцээ дотооддоо эрүүл чанартай хүнсээр албан хаагч, ялтныг бүрэн хангаж чадах боломжийг бий болгох;

17/ Төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгийг бэлтгэхдээ зардлын зүйл, заалтын дагуу бэлтгэж, зайлшгүй шалтгааны улмаас эх үүсвэр нь хүрэлцэхгүй, зардлын зүйл заалт тохирохгүй бол холбогдох баримт болон үндэслэлийг гаргаж хүсэлтээ ирүүлнэ. Мөн бусад эх үүсвэрээр бэлтгэх үндсэн хөрөнгийг худалдан авахаас өмнө холбогдох дээд байгууллагад хүсэлт гаргаж, зохих зөвшөөрөл /Төрийн өмчийн хорооны зөвшөөрөл/ гарсны дараа бэлтгэх бөгөөд байгууллага хооронд шилжүүлж буй хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй балансаас балансад /Ерөнхий газрын даргын тушаал, Төрийн өмчийн хорооны шийдвэр/ шилжүүлэхгүй байх;

18/ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 2014 онд батлан хүргүүлсэн эдийн засаг, санхүүгийн хяналтын тоог үндэслэн төсвийн зарлагын болон техник, үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /ТҮСТ-г зохиож, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах.

Гурав. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, төсвийн санхүүжилтийг зориулалтын бус зүйлд зарцуулсан албан тушаалтанд хариуцлага тооцож, тухай бүр гаргасан зөрчлийг залруулах арга хэмжээг авч, тушаалын заалт нэг бүрийн биелэлтийг улирал бүр тооцож ажиллахыг Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газар /хурандаа М.Хуягбаатар/, Дотоодын хяналт шалгалт, аюулгүй байдал хариуцсан дэд дарга, хурандаа Г.Элбэгсайханд тус тус даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА

ХУУЛБАР ҮНЭН:
Захиргааны удирдлагын газрын
дарга, дэд хурандаа
2014.01.09



Д.ЯДАМДОРЖ

П.Гантөмөр